

“ҮЦТХТ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

М.ЭНХСАЙХАН

“.....” ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/...../

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

20 ... оны ... сарын ...өдөр

№

Улаанбаатар хот

Нэг талаас “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид “ҮЦТХТ” ХХК гэх/ нөгөө талаас “.....” ХХК /цаашид ҮЦК гэх/ бид /хамтад нь талууд гэх/ Монгол Улсын Иргэний хуулийн 48 дугаар бүлгийг үндэслэн дараах нөхцөлөөр хамтран ажиллахаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээгээр талуудын хамтран ажиллах нөхцөл, журам, талуудын эрх үүргийг тогтоох, ҮЦК-иар зуучлуулан харилцагчдын мөнгөн хөрөнгийг шилжүүлэх болон бусад төлбөр тооцоог гүйцэтгэх, үнэт цаас, мөнгөн хөрөнгийг хадгалах, түүний бүрэн бүтэн байдлыг хариуцах, ҮЦК нь үйлчилгээний хөлс, шимтгэлийг саадгүй төлөхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Гэрээтэй холбогдон үүсэх харилцаанд Үнэт цаасны зах зээлийн тухай болон иргэний хууль тогтоомж, “ҮЦТХТ” ХХК-ийн холбогдох журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. “ҮЦТХТ” ХХК-ийн эрх, үүрэг

2.1 “ҮЦТХТ” ХХК нь ҮЦК-иас ирүүлсэн анхан шатны баримтыг үндэслэн төвлөрсөн хадгаламжинд ҮЦК ийн харилцагчийн данс нээх, ҮЦК-ийн хооронд үнэт цаас шилжүүлэх, мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээг хийх, төвлөрсөн хадгаламжийн данс хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлэх гүйлгээг үнэн зөв хийх;

2.2 ҮЦК-ийн дансны үлдэгдлийн мэдээ болон тодорхойлолтыг гаргаж өгөхдөө “ҮЦТХТ”

ХХК-ийн “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийн үйл ажиллагааг бүртгэх журам”, “Хадгаламжийн журам”-ыг баримтална. ҮЦК-иас ирүүлсэн анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй буюу уг баримт нь “Байгууллагын архивын үндсэн заавар”-ын 3.3 ба 3.4 дэх заалтын шаардлага хангаагүй тохиолдолд уг баримтыг буцаах, дутуу нөхцөлд нэмж бүрдүүлэхийг шаардах;

2.3 ҮЦК-ийн харилцагчдын үнэт цаасны төлбөр тооцоо, гүйлгээнээс батлагдсан журмын дагуу үйлчилгээний хөлс, шимтгэл авах;

2.4 Үйлчилгээний хөлсийг хугацаанд нь төлөөгүй ҮЦК-д хөлсөө төлөхийг шаардах, мөнгөн хөрөнгө, үнэт цаасны төлбөр тооцоо, гүйлгээг хийх болон бусад үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

2.5 Харилцагчийн төвлөрсөн хадгаламж дахь дансны ерөнхий болон мөнгөн хөрөнгө, үнэт цаасны гүйлгээтэй холбоотой мэдээлэл, дансны үлдэгдлийн нууцыг хадгалах;

2.6 Энэхүү гэрээтэй холбоотой “ҮЦТХТ” ХХК-д мөрдөгдөж байгаа журамд үйлчилгээний хөлс, шимтгэл зэрэг харилцагчид шууд чиглэсэн өөрчлөлт орох тухай бүр ҮЦК-д мэдэгдэх, бусад өөрчлөлтийн талаар өөрийн цахим хуудас, тухайн ҮЦК-ийн албан ёсны цахим хаяг болон мэдээллийн самбараар тухай бүр нь мэдээлэх;

2.7 ҮЦК нь өөрийн харилцагчидтай харилцан тохиролцож тогтоосон шимтгэлийн хувийг талууд хүсэлт гаргаагүй тохиолдолд гуравдагч этгээдийн хүсэлтээр өөрчлөхгүй байх;

2.8 “ҮЦТХТ” ХХК нь харилцагчдын орлого, зарлагын гүйлгээг хийхдээ компанийн дүрэм, журамтай зөрчилдсөн мөнгөн хөрөнгийн гүйлгээ болон бусад төлбөр тооцоог хийхээс татгалзана.

2.9 “ҮЦТХТ” ХХК нь дансны хураамжийн төлбөрийг урьдчилж байршуулах ба төлбөрөө хийгээгүй ҮЦК-ийн дансыг нээхээс татгалзана.

Гурав. ҮЦК-ийн эрх, үүрэг

3.1 ҮЦК нь “ҮЦТХТ” ХХК-иас нээгдсэн дансны файл /ҮЦК_Огноо.vcdt/, арилжааны бус гүйлгээний файл /ҮЦК_Огноо.vctf/-аа үүсгүүлж авах тохиолдолд “ҮЦТХТ” ХХК-ийн “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийн үйл ажиллагааг бүртгэх журам”-ыг мөрдлөг болгоно;

3.2 ҮЦК нь бусад ҮЦК-тай нэгдсэн тохиолдолд СЗХ-ны шийдвэрээр харилцагчдын холболтын дансыг нээлгэхдээ “ҮЦТХТ” ХХК-ийн “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийн үйл ажиллагааг бүртгэх журам”-ын дагуу нээлгэнэ;

3.3 ҮЦК нь анх шинээр гэрээ байгуулахдаа доорх баримтыг бүрдүүлж хавсаргана. Үүнд:

3.3.1 Компанийн аж ахуйн нэгжийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар /гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн/

3.3.2 Харилцагчдын мөнгөн хөрөнгийн гүйлгээний баримтанд гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны гарын үсгийн баталгаа /нотариатаар батлуулна/;

3.3.3 Албан тушаалтны иргэний үнэмлэхийн хуулбар;

3.3.4 Албан тушаалтны Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхийн хуулбар, хавсралтын хамт;

3.3.5 ҮЦК нь “Хамтран ажиллах гэрээ”-ний б.1-д заасан хугацаа дууссан тохиолдолд гэрээг дахин заавал бичгээр байгуулна.

3.3.6 ҮЦК-ийн аж ахуйн данс дахь үнэт цаас, мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтныг томилсон тухай шийдвэр, тухайн албан тушаалтны гарын үсгийн баталгааг хүчинтэй иргэний үнэмлэхийн хуулбарын хамт ирүүлнэ.

3.4 ҮЦК-ийн гүйлгээ хийх эрх бүхий албан тушаалтан болон ажилтан өөрчлөгдөх, мөн байршил, утасны дугаар, бусад мэдээ, мэдээлэл, үйл ажиллагаатай холбоотой өөрчлөлтүүдийг тухай бүр “ҮЦТХТ” ХХК-д албан ёсоор мэдэгдэнэ.

3.5 Харилцагчийн төвлөрсөн хадгаламж дахь дансны үзүүлэлт өөрчлөгдсөн тухай бүр холбогдох баримтуудыг хавсарган “ҮЦТХТ” ХХК-д албан тоотоор мэдэгдэж өөрчлөлтийг бүртгүүлнэ.

3.6 Төвлөрсөн хадгаламжид шинээр данс нээлгэх аж ахуйн нэгжийн дансны захиран зарцуулагчийн гарын үсгийн баталгааг холбогдох журмын дагуу гаргуулан ирүүлнэ.

3.7 ҮЦК нь төвлөрсөн хадгаламжид данс нээх гэрээ болон мөнгөн хөрөнгийн гүйлгээний анхан шатны баримтуудад гарын үсэг зурах эрх бүхий ажилтан албан тушаалтныг томилж, дараах баримтын бүрдүүлбэрийг “ҮЦТХТ” ХХК-д хүргүүлнэ. Үүнд:

3.7.1 Тухайн ажилтныг томилсон тушаалын хуулбар;

3.7.2 Ажилтны гарын үсгийн баталгаа;

3.7.3 Ажилтны цахим үнэмлэхийн хуулбар;

3.7.4 Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхийн хуулбар;

3.8 Харилцагчийн ҮЦК дахь дансны ерөнхий болон мөнгөн хөрөнгө, үнэт цаасны гүйлгээтэй холбоотой мэдээлэл, дансны үлдэгдлийн нууцыг хадгална.

3.9 ҮЦК нь өөрийн харилцагчдад “ҮЦТХТ” ХХК-ийн мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдэх зарчмыг тайлбарлах, бусад төлбөр тооцоотой холбоотой шаардлагатай мэдээллээр хангана.

3.10 ҮЦК нь данс нээх гэрээний маягтад өөрийн компанийн хаяг, холбоо барих утасны дугаарыг тусгах ба ҮЦК-ийн байршил, утасны дугаарт өөрчлөлт орсон тухай бүрт харилцагчиддаа тогтмол мэдээлэх, “ҮЦТХТ” ХХК-д албан ёсоор мэдэгдэнэ.

3.11 ҮЦК нь баннер сурталчилгааг “ҮЦТХТ” ХХК-ийн цахим хуудсанд хөнгөлөлттэй үнээр байршуулж болно;

3.12 ҮЦК нь “ҮЦТХТ” ХХК-ийн Мөнгөн хөрөнгийн гүйлгээний журмын 3.3-т заасны дагуу гүйлгээ хийлгэхдээ Мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх гурвалсан гэрээг заавал байгуулсан байх шаардлагатай.

Дөрөв. Үйлчилгээний хөлс

4.1 “ҮЦТХТ” ХХК-иас ҮЦК-д үзүүлж буй үйлчилгээний хураамж улирлын 100,000 /нэг зуун мянган/ төгрөг байна. Үйлчилгээний хураамжийг бүтэн жилээр төлсөн тохиолдолд 320,000 /гурван зуун хорин мянган/ төгрөг болгож хөнгөлөх ба хураамжийг жилийн эхний сарын 15-ны өдрийн дотор төлсөн байна. “ҮЦТХТ” ХХК- иас ҮЦК-д дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

4.1.1 Харилцагчийн “Төвлөрсөн хадгаламжийн данснаас мөнгө хүсэх өргөдөл”- ийн дагуу мөнгөн хөрөнгийг харилцагчийн арилжааны банк дахь данс болон Төрийн банкаар дамжуулан гадаад улс дах банкны дансанд шилжүүлэх;

4.1.2 Харилцагчдын тухайлсан бүртгэлийг анхан шатны баримттай тулган баталгаажуулж, найдвартай хадгалах, төлбөр тооцоог хийж гүйцэтгэх;

4.1.3 ҮЦК-ийн анхан шатны баримтын үнэн зөв, найдвартай ажиллагааг хангах үүднээс ҮЦК-ийн ажилтан, албан тушаалтны гарын үсгийн баталгаа, тамга, тэмдэгийн бүртгэлийг хуучин “И-клиринг хаус” системд бүртгэх;

4.1.4 Хэд хэдэн ҮЦК-иар үйлчлүүлж буй хөрөнгө оруулагчдыг нэгдсэн мэдээллээр хангах онлайн үйлчилгээг үзүүлэх;

4.1.5 ҮЦК-ийн ажилтнуудын CSD системд нэвтрэх эрхийн зохицуулалтыг ҮЦК- ийн хүсэлтийн дагуу тухай бүр хийж гүйцэтгэх;

Тав. Талуудын хүлээх хариуцлага

5.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцаж барагдуулна.

5.2 ҮЦК-иас ирүүлсэн анхан шатны баримтын бүрдэл болон бүрдлийн үнэн зөвийг ҮЦК бүрэн хариуцах бөгөөд уг гэрээний 3.3 заалтыг хэрэгжүүлээгүйн улмаас үүсэх аливаа хариуцлагыг “ҮЦТХТ” ХХК хүлээхгүй.

5.3 ҮЦК нь үйлчилгээний хөлсийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хэтэрсэн хоног тутамд 0.3 хувийн алданги төлнө.

Зургаа. Гэрээний хугацаа, гэрээг цуцлах үндэслэл

6.1 Энэхүү гэрээг нэг жилийн хугацаагаар байгуулах ба гэрээг цуцлах тухай хүсэлт аль нэг талаас ирүүлээгүй тохиолдолд гэрээг мөн хугацаагаар сунгагдсанд тооцно.

6.2 Үйлчилгээний хөлсийг 1 улирал төлөөгүй нь гэрээг цуцлах үндэслэл болно.

6.3 Эрх бүхий байгууллагаас олгосон брокер дилерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан тохиолдолд нийслэлд ажлын 14 хоног, орон нутагт ажлын 22 хоногийн дотор холбогдох тооцоог хийж дуусгаснаар гэрээг цуцална.

Долоо. Бусад зүйл

7.1 ҮЦК нь нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах зэргээр зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж буй тохиолдолд ажлын 10 хоногийн өмнө “ҮЦТХТ” ХХК-д урьдчилан бичгээр мэдэгдэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоол гарах хүртэл хугацаанд гэрээг хүчинтэйд тооцно.

7.2 Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

7.3 Аль нэг талын бичгээр ирүүлсэн хүсэлтээр талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулж болно. Ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.

7.4 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд тохиролцоонд хүрэх замаар шийдвэрлэх ба тохиролцоонд эс хүрвэл талууд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“ҮЦТХТ”ХХК-ИЙГ

“.....” ХХК-ИЙГ

ТӨЛӨӨЛЖ:

Захиргаа, Хууль Эрх Зүй, Санхүүгийн

Газрын Захирал:

.....

/Ж.Амарсайхан/

ТӨЛӨӨЛЖ:

Гүйцэтгэх захирал:

.....

/ /

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,

Самбуугийн гудамж-16/1,

Утас: 70120460

и-мэйл:info@mcsd.mn,

Факс: 70114424

Хаяг:

Утас:

и-мэйл:

Факс: